



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 09 сарын 03 өдөр

Дугаар 4/336

Улаанбаатар хот

Инженерийн баг,
хяналтын инженер томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Иргэний нисэхийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.7 дахь заалт, Иргэний нисэхийн дүрэм-171 “Агаарын навигацийн үйлчилгээний техникийн байгууллага – үйл ажиллагаа ба гэрчилгээжүүлэлт”-ийн 171.79-ийн 6.2 “Байгууламжийг суурилуулах ба ажилд хүлээн авах журам”-ын 6.2.4.1, 6.2.6.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Баруун 4 аймгийн онгоц хөөрч буух хатуу хучилттай зурвасын гэрэл суултын систем суурилуулах /Увс, Говь-Алтай, Завхан, Баян-Өлгий/ ИНЕГ/ТББ/Б-01/11 дугаар гэрээний дагуу нийлүүлэгдсэн гэрэл суултын системийн иж бүрдлийг Говь-Алтай аймгийн Алтай нисэх буудалд 2018 оны 9 дүгээр сарын 24-ний өдрөөс 10 дугаар сарын 21-ний өдрүүдэд, Хөвсгөл аймгийн Мөрөн нисэх буудалд 2018 оны 9 дүгээр сарын 05-ны өдрөөс 9 дүгээр сарын 17-ны өдрүүдэд суурилуулах ажлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэх инженерийн баг, хяналтын инженерийг нэрсийг хавсралтаар баталсугай.

2. Суурилуулалтын ажлыг агаарын навигацийн байгууламжуудын хэвийн ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүйгээр нислэгийн аюулгүй ажиллагааг бүрэн хангахаар зохион байгуулж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгааг мөрдөж ажиллахыг инженерийн багийн ахлагч /Г.Энхболд/-д, суурилуулалтын ажилд хяналт тавьж ажиллахыг хяналтын инженер /А.Амгалан/-т тус тус үүрэг болгосугай.

3. Суурилуулалтын ажлын явц болон гүйцэтгэлийг цаг хугацаанд нь, батлагдсан төлөвлөгөөний дагуу чанартай гүйцэтгэхэд хяналт тавьж ажиллахыг Холбоо, навигаци, ажиглалтын алба /Д.Баяртогтох/-нд үүрэг болгосугай.

ДАРГА | Л.БЯМБАСҮРЭН

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын
2018 оны 03 дүгээр сарын 03-ны өдрийн
А/356 дугаар тушаалын хавсралт



Гэрэл суултын системийг суурилуулах ажлыг хийж гүйцэтгэх
инженерийн баг, хяналтын инженерийн бүрэлдэхүүн

1. Говь-Алтай аймгийн Алтай нисэх буудалд:

Инженерийн багийн

ахлагч: Г.Энхболд Холбоо, навигаци, ажиглалтын
албаны Гэрэл суулт, цахилгааны
хэсгийн Гэрэл суултын тасгийн ахлах
инженер

Гишүүд: М.Баяраа Холбоо, навигаци, ажиглалтын
албаны Гэрэл суулт, цахилгааны
хэсгийн Гэрэл суултын тасгийн
инженер

А.Алтансүх Говь-Алтай аймаг дахь нисэх буудлын
гэрэл суулт, цахилгааны техникч

Хяналтын
инженер: А.Амгалан Холбоо, навигаци, ажиглалтын
албаны Гэрэл суулт, цахилгааны
хэсгийн Гэрэл суултын тасгийн ахлагч
инженер

2. Хөвсгөл аймгийн Мөрөн нисэх буудалд:

Инженерийн багийн

ахлагч: Г.Энхболд Холбоо, навигаци, ажиглалтын
албаны Гэрэл суулт, цахилгааны
хэсгийн Гэрэл суултын тасгийн ахлах
инженер

Гишүүд: М.Баяраа Холбоо, навигаци, ажиглалтын
албаны Гэрэл суулт, цахилгааны
хэсгийн Гэрэл суултын тасгийн
инженер

Ё.Батбаяр Хөвсгөл аймаг дахь Мөрөн нисэх
буудлын гэрэл суулт, цахилгааны
техникч

Хяналтын
инженер: А.Амгалан Холбоо, навигаци, ажиглалтын
албаны Гэрэл суулт, цахилгааны
хэсгийн Гэрэл суултын тасгийн ахлагч
инженер